

Монгол мэт жижиг улс үндэстэнд НҮБ нь эрх чөлөө, тусгаар тогтнолын нэг чухал улс төрийн баталгаа болох учиртай.

Монгол улс хөгжлийнхөө шинэ үе шатанд орлоо. Энэ үе шат түүнд өргөн боломж нээж өгч байгаагийн сацуу том том шийдвэрлэх асуудлыг үүдэж байна. Миний үзэж байгаагаар гол ололт бол Монгол өөрөө өөрийгөө таньж ойлгон, эргэн тойрондоо юу болж буйг өөрийн нүдээр харах боломжтой болсон явдал юм.

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын гол зарчмууд тэрчлэн цэргийн номлолын үндэс нь Монгол өөрийгөө болон бусдыг таньж ойлгосон шинэ үзлийн тусгал болж байна. Тэдгээр үзэл баримтлал нь чулуунд сийлсэн, өөрчлөгдөшгүй зүйл биш бөгөөд монголын дотоодод болон гадаад ертөнцөд буй болж байгаа өөрчлөлтүүд нь тэдгээр баримтлалыг зохих хэмжээгээр өөрчлөх болно. Ийм утга санаа ч дээрхи баримтлалуудад тусгагдсан юм. Эдгээр баримтлалууд эдүгээ нэгэнт нийтлэгдсэн учир хэдүйнээ уншигчдын хүртээл болсон билээ.

Англи хэлнээс орчуулсан Э.Пунцаг

(Энэ өгүүллийн эхийг "The Mongolian journal of international affairs" Сэтгүүлийн №5-д үзнэ үү).

**Монгол улсын геополитик, хөгжлийн
1990-ээд оны онцлог**

Элчин сайд Х.Олзвой

**Нэг. Монгол улсын геополитикийн
өвөрмөц тал.**

Аливаа улсын газар зүйн байршил нь тэр орны хөгжил, гадаад харилцаа, аюулгүй байдал, их гүрнүүдийн бодлогод гүйцэтгэх үүргийг тодорхойлдог. Монгол бол бүр ч өвөрмөц онцлогтой орон. Яагаад вэ гэвэл:

1.Далайд гарцгүй, гэхдээ хүрээлдэг хоёр орон нь хүч тэнцвэргүй аваргууд учир далайд гарцтай болох эрхээ баталгаажуулж ч чадаагүй байсан.

2.Цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн, тэгэхдээ бүр коммунист хоёр хөршийнхөө үзэл суртлын маргаанд ч өртөхөөр бодлогыг эрх баригчид нь явуулж байсан болохоор үй

олноор устгах зэвсэгт ч онилуулсан байсан байж болзошгүй орон.

3.Дэлхийн зах зээлээс алслагдлагдсан төдийгүй нэг орноос хэт их хамааралтай болсон байсан;

4.Дэлхийн эдийн засгийн интеграцчилалын аль ч бүлэглэлд хамаарагдаагүй, хамаарагдах төлөв нь ч их хол.

Монгол улс сүүлийн олон арван жил хуучин ЗХУ-ын “өмгөөлөл, хамгаалалд байгаа мэт боловч түүнээс цэрэг-улс төр, эдийн засаг, оюун санааны амьдрал зэрэг олон салбарт “их ах”-аасаа хараат байдалд орсон. Үүний хэдхэн жишээ гэхэд:

-Цэрэг зэвсгийн хувьд ОХУ-аас бараг 100 хувийн хараат байдалд байсаар байна. Буудлагын зэвсгээс пуужин, онгоц хүртэл бүх зэвсэг техник ОХУ-аас гаралтай, хуучин ЗХУ-ын бүтээгдэхүүн.

Армийн офицерын бие бүрэлдэхүүн бараг бүхэлдээ ЗХУ-д боловсрол мэдлэг олсон хүмүүс.

-Худалдааны хамаарал маш их гэдгийн баталгаа нь газрын тосны бүтээгдэхүүнийг үндсэндээ ОХУ-аас авч буй явдал юм. Энэ хараат байдал цаашид ч олон жил үргэлжилэх болов уу. Мөн гадаад худалдааны эргэлтэд ОХУ-ын эзлэх жин эхний байрт цаашид ч байх нь ойлгомжтой. Харин сүүлийн үед Монголын экспортын хувь буурсаар байгаа нь сэтгэл зовоосон зүйл мөн. Монгол улсын уламжлалт бараа таваарын хувьд ОХУ тэргүүлэх байр суурьтайг дурдалтай. Импортын хувьд гэхэд л 50 гаруй хувийг ОХУ дангаараа эзэлж буй нь Монголын хараат, хамааралтай байдлыг илтгэнэ. Зарим тооцооноос үзвэл Монголын импортод эрдсийн бүтээгдэхүүн 20,3%, цахилгаан эрчим хүч 5,0%, төрөл бүрийн машин механизм, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл 21,0%, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, эд ангийг үндсэнд нь ОХУ-аас авч буй нь импортын хамаарлыг харуулж байна (ГХЯ-ны мэдээ).

-Өр зээлийн хувьд ч ОХУ-аас нэн хамааралтай гэгдэж байгаа билээ.

-Оюуны чадавхийн талаар ч ОХУ-аас буюу хуучин ЗХУ аас ихээхэн хамааралтай. Монголын дээд боловсролтой боловсон хүчний 40%, эрдэмтдийн 60% нь ЗХУ-д бэлтгэгдсэн, эрдмийн зэрэг хамгаалсан гэсэн тоо бий.

Монголчууд хойд хөршийнхөө зөвлөх нараар бүх юмаа заалгаж ирсэн, бэлэнчлэх, хуулбарлах үзэлд ихээхэн ууссан хүмүүс гэхэд их хилсдэхгүй. Энэ нь сэтгэн бодохуйн хараат

байдал бөгөөд энэ нь өнөөдөр ч амь бөхтэй үрэлжилсээр байгаа нь хараат байх, том гүрнийг хэт шүтэж байсны илрэл юм. Энэ хэдхэн баримтаас харахад л Монгол бол туйлын оросжсон орон гэдэг нь харагддаг.

Өмнөд хөршийн нөлөө, анхаарал чих байсан гэдгийг хэлэх хэрэгтэй. Хятад гүрэн улам хүчирхэгжин байгаа нь уулаасаа Монголыг өөрийн мэдлийн гэх үзэл, түүхэн үеүүдэд тус орны тусгаар тогтнолын асуудлаар Орос, ЗХУ хийгээд бусадтай түүний хойгуур сэм хуйвалдаж байсан, санхүү, эдийн засгийн далд бодлоготой гэдгийг нь мартаггүй байхыг үйл явдлууд сануулсаар байна. Мөн Монгол улс далайд гарах дөт гарц БНХАУ-аар дайрдаг, дэлхийн зах зээлд нэвтрэх зам энэ оронтой улам холбоотой болж буй зэргийг бодох ёстой.

Хуучин ЗХУ Монгол орныг өөрийн дагуул болгон коммунизмын гаваар гинжилсэн байсан тул бусад том гүрэнтэй ч харилцах гарц гүүргүй, тэд ч тэр жижиг дагуулыг олж харахыг төдийлөн хүсэхгүй байлаа. Үүнийг Монголоо гэсэн хүн бүр ойлгож дэлхийн тавцанд гарах, бусад их гүрнүүд болон НҮБ, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэгтэй холбон үзэж тэдэн лүү дөхөхийг хичээсээр ирсэн нь түүхээс илэрхий! 1911 оны хувьсгалыг удирдсан зүтгэлтнүүд, тусгаар тогтнолоо сэргээж хувьсгал хийгчид бүгд л энэ чиглэлийг баримталж байсан билээ. Олон ч хүн егүүтгэгдсэн нь түүхэн баримт юм.

Харин 1990-ээд онд олон улсын харилцааны байдал бүхэлдээ өөрчлөгдөж сэргөөлдөөнөөс хамтарч ажиллах, бие биеийг дайсан гэж үзэхээс татгалзах буюу бие биеийн эрх ашгийн тэнцвэрийг барих хандлагад шилжсэн хийгээд коммунист ертөнц, түүний гол тулгуур -ЗХУ задарсан бөгөөд хуучин социалист гэгдэж байсан бараг бүх орон хүн төрөлхтний хөгжлийн шалгагдсан гольдиролд нэгдсэн нь Монгол мэтийн орны хувьд ч хөгжлийн тодорхой шинэ төлвийг бий болгов.

Монгол улс хөрш хоёр хэт их гүрний тойргоос аажмаар гарч гадаад харилцаандаа олон тулгуурт байдалд шилжих түүхэн үе нээгдсэн нь 1990-ээд оны ардчилсан өөрчлөлт шинэчлэлтэй нөхцөлдсөн юм. Чухамхүү энэ үндсэн дээр Монгол улс өөрийн гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлалтай болж (1994 оны 6 дугаар сарын 30-нд УИХ-аар батлагдсан) гадаад бодлогын хараат байдлаасаа гарах талаар томоохон алхам хийлээ. Үзэл суртлын хаагдмал байдлаас гарч

эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны хувьд ч газар зүйн чиглэлээ тэллээ.

Монгол Улсын бодлого, байр суурьт сүүлийн жилүүдэд зөв зүйтэй, стратегийн гэхээр олон өөрчлөлт гарснаас нэрлэвэл:

-Монгол улс ардчилал, зах зээлийн замыг эргэлт буцалтгүй сонгож хүн төрөлхтний хөгжлийн гольдролд орсон;

-Монгол улс нээлттэй бодлого явуулж дэлхийн бүх улс гүрэнтэй чөлөөтэй харилцах болсон;

-Хоёр хөрш улстайгаа харилцахдаа бүхэлдээ адил тэнцвэртэй бодлого явуулж найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулах зэргээр харилцааныхаа эрх зүйн үндсийг шинэ нөхцөлд тохируулан бэхжүүлсэн;

-АНУ, Япон зэрэг гүрнүүдтэй харилцах талаар гүнзгий шинэчлэл хийж, өөрийн орондоо хэрэгжүүлж буй ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих бодлогыг баттайгаар дэмжүүлж чадсан гэх мэт.

Эдгээр нь геополитикийн хувьд өгөөжтэй бөгөөд улс орны хөгжлийг түргэтгэхэд стратегийн ач холбогдолтой алхмууд юм.

***Хоёр. 1990-ээд оны геополитикийн
зарим онцлог.***

ЗХУ задарсны дараа Монголын гео-стратегийн байдалд нилээд өөрчлөлт ороод байна гэж хэлж болох юм:

Нэгд: Монгол Улс бүрэн дагавар улсын статустай байхаа болив.

Хоёрт: ЗХУ-ын цэрэг гарсны дараа Монгол нь хоёр талын улс төр, цэргийн дарамтаас гарч хоёр хөршийн шууд мөргөлдөөний талбар болох магадлалаас лав нэг хэсэгтээ гарав.

Гуравт: Хоёр хөршийн хооронд хилийн асуудал шийдвэрлэгдсэн хийгээд стратегийн чанартай тохиролцоонууд бий болов. Тэд ч өөр өөрсдийн дотоод, гадаад том зорилтоо хэрэгжүүлэхэд илүү анхаарах болов.

Дөрөвт: АНУ-ын Ази, Номхон далай дахь тогтворжуулах хийгээд тэнцвэржүүлэх стратегийн үүрэг өсөн нэмэгдэв.

Тавд: Зүүн Хойд Ази дахь газар нутгийн маргааны болон Солонгосын хойгийн асуудал харьцангуй бүдгэрч “Сэрэмжлэн зайлуулах” дипломатын арга, эдийн засгийн хамтын

ажиллагаанд шилжих чиглэл давамгайлах болов. Эдгээр нь Монголын геостратегийн байдлыг хөнгөлж үндэсний язгуур эрх ашгиа дээдэлсэн, бие даасан бодлого явуулах сайхан бололцоо олгож байна.

Их гүрнүүдээс Монголд хандаж буй байдалд ч өөрчлөлт орж буй нь мэдрэгдэх боллоо. Жишээлбэл:

БНХАУ Монголын хувьд явуулах дипломат бодлогоо идэвжүүлж, давшингуй хэлбэрт оруулав.

Аливаа ард түмний сонгосон замыг хүндэтгэхээ илэрхийлж улмаар Монголын тусгаар тогтнолыг хүндэтгэх тухайгаа найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээ (1994 он)-нд тусгахыг зөвшөөрөв. Дээд хэмжээний төлөөлөгчдөө Монголд удаа дараагаар ирүүлж Монголын удирдагчдыг ч хүлээн авч албан ёсоор айлчлуулах нь олшров.

Оросын хэт нөлөөнөөс татан гаргах чиглэлийн энэ ажиллагаанд эдийн засгийн дипломат арга барилаа ч ашиглаж байна (урт хугацааны хүүгүй зээл, тусламж олгох г.м)

Хоёр орны хил бол БНХАУ-ын хувьд бусад улстай нийлж буй хамгийн урт (4673 км) Хил гэдгийг Хятадын удирдагчид цохон тэмдэглэхийн хамт Ли Пэн Монгол-Хятадын хил бол энх тайваны хил гэсэн томъёолол гаргав.

ОХУ Монголыг хуучин шигээ бүрэн хараат байдалтай дагуул улсын хэмжээнд хадгалж чадахаа нэгэнт өнгөрснөө хүлээн зөвшөөрч шинэ гэрээ, хэлэлцээрүүд байгуулав.

Оросын аюулгүй байдлын хувьд Монгол бол чухал үүрэгтэй учраас түүний геостратегийн ач холбогдол улам өслөө гэж акад. Г.Арбатов зэрэг олон судлаач-эрдэмтэд цохон дурдаж байна.

ОХУ-ын Гадаад харилцааны сайд Е.Примаков ч Монгол бол ОХУ-ын хувьд бамбай улс мөн гэж Улаанбаатарт хийсэн айлчлалынхаа явцад хэлсэн билээ.

1995-оны 3 дугаар сард МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн хариуцан зохиосон “Монголын геостратегийн өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт олон улсын бага хурал дээр Оросын стратегийн судлалын хүрээлэнгийн судлаач И.А.Николайчук тавьсан илтгэлдээ БНХАУ-тай ОХУ харилцаагаа сайжруулахдаа болгоомжтой хандах ёстой гээд “Чингэхдээ Орост найрсаг, түүнээс ч илүү (өөрөөр хэлбэл, стратегийн холбооны харилцааг хэлж байна) харилцаатай Монгол оршин байхыг сонирхож байна, тэр бүү хэл төвийг сахисан байлаа ч Монгол нь Оросын аюулгүй байдлыг

хангахад нааштай үүрэг гүйцэтгэсээр байх болно” гэж дурджээ. Тэрээр цааш нь Монгол нь Хятадын нөлөөний хүрээнд орох буюу эсвэл ил далд аль ч хэлбэрээр тусгаар тогтнолоо алдах нь бүс нутгийн тогтвортой байдлыг алдагдуулах юм гэж ч үзэж болно гэсэн байна.

АНУ Монголын 1990 оны ардчилсан хувьсгалыг анхнаас нь талархан дэмжиж, мөн онд хоёр орны харилцааны түүхэнд анх удаа тэр үеийн төрийн нарийн бичгийн дарга Ж. Бейкер албан ёсны айлчлал хийсэн. Монголын газар зүйн өвөрмөц байдлыг ойлгож, түүний эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг нь дэмжин стратегийн ач холбогдлоо мэдэрч байгаа түнш.

Япон өсөн нэмэгдэж буй түүхий эдийнхээ хэрэгцээний хүрээнд, Азид улс төрийн нөлөөгөө бэхжүүлэх стратегийн бодлогынхоо дагуу Монголыг сонирхож судлаж, хандивлагчдын бүлгийг ч зохион байгуулах зэргээр идэвх гаргасаар байна.

Зүүн Хойд Азийн эдгээр том гүрнүүд XXI зуун руу харж геополитик, гео-эдийн засгийн асуудлаа төлөвлөж түүнийхээ хүрээнд Монгол улс нь хүн ам цөөтэй, арвин уудам нутагтай, газрын их баялагтай, тэр бүү хэл ирэх зуунд ч шавхагдашгүй цэвэр усны нөөцтэйг ч анхаарч буй нь мэдээж ойлгомжтой.

Дурдсан хурал дээр Оросын дипломатч Ю.Кручкин “Сүүлийн 10 жилд Евро-Азид гарсан үндэстний болон шашны өөрчлөлтийн улмаас Монгол нь ойрын жилүүдэд дэлхийн 3 шашин (христ, лал, будда)-ы уулзвар хийгээд слав болон күнзын сургаалын хил дээр байж, бас дэлхийн хамгийн эрчтэй хөгжиж буй орон болох Япон, Хятад, Өмнөд Солонгос, мөн хүчтэй Орос, энэ бүсэд оролцоогүй биш АНУ-ын нөлөөллийн шугамууд солиболцох яг тэр төвд оршдог өвөрмөц байдлыг бий болгожээ” гэж тодорхойлсон нь сонирхолтой. Энэ бол Монголын газар нутгийн байршлын бас нэг өвөрмөц байдал, хөгжил дэвшлийн явцад гарах олон асуудлыг ч хөндөж төрийн уян хатан, цэгцтэй бодлого хэрэгжүүлэх нь зүйтэйг харуулж байна.

Гурав. Зүүн тийш харж
хөгжье

Өмнө дурдсан бүлгүүдээс үзвэл Монгол улсад “Зүүн тийш харж хөгжих” зам тавигдаж эхлэв. Газар зүйн хувьд

Монголыг Төв Азийнх гэж олон зууны турш ярьж бичиж ирсэн нь үнэн. Гэвч газар зүйн энэ бүс нь нэгдүгээрт, далайд гарцгүй, хоёрдугаарт, улс орны хувьд төлөвшөөгүй бөгөөд эдийн засгийн хувьд ОХУ-аас хамааралтай олон оронтой, гуравдугаарт, газарзүйн хувьд Монголоос алслагдсан, зам тээврийн бэрхшээлтэй, дөрөвдүгээрт, аюулгүй байдлын үзэл санааны хувьд ч Монголд нөлөөлөл багатай гэхээр улсуудтай учраас зүүн тийш харж хөгжих нь зөв гэсэн үзэл бодлоо зохиогч хэд хэдэн удаа илэрхийлсэн билээ (“Дорно-Өрнө” сэтгүүл, 1996 оны № 2..). Зүүн Хойд Азид багтдаг болон далайн чанад дахь гүрнүүдийн бие биеэ эдийн засаг, аюулгүй байдал, бусад талаар нөхөх бололцоо, Монголыг БНХАУ-ын Зүүн хойд хэсгээр дамжуулан бусад оронтой холбох зам тээврийн ойр дөт байдал зэрэг олон давуу талыг дурдаж болох юм.

Зүүн тийш харж хөгжихийн бусад зарим нааштай талыг зохиогч дорхи байдлаар төсөөлдөг. Үүнд:

-Монгол орон стратегийн хувьд техник, технологийн салбарт нэн түрүүлсэн гүрнүүд болох Япон, АНУ, тэрчилэн Азийн барууд, юуны өмнө БНСУ-ын эдийн засгийн “шүхэр”-т багтана. Тус орны хамтын ажиллагаа Оросын Алс Дорнод, Хятадын Зүүн Хойд мужууд, мөн БНАСАУ-тай ихээхэн өргөжинө.

-Манай орны ойролцоогоор 207 мянган ам дөрвөлжин км.нутаг, 137 мян. хүн амтай дорнод бүс (Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг) нь газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх өргөн боломжтой бөгөөд байгалийн их баялагтай, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн билээ. Энэ хэсгийг юуны өмнө ЗХА-тай холбон, Түмэн голын төслийн хэсэг болгон оруулах боломж өгнө.

-Монгол улс ЗХА-ийн орнуудтай төмөр зам, хатуу хучилттай зам зэргээр холбогдож далайд гарах бас нэг гарцтай болно.

-Монгол улс ЗХА, Европын газар гүүр болж дэд бүтэц хөгжиж гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж улмаар тээвэр холбооны хөгжилд ахиц гарна.

Энэ бүс нутгийн цэрэг, улс төрийн байдал шинэ нөхцөлд, тухайлбал 1990-ээд онд хэрхэн өөрчлөгдөж буйг товч ч атугай авч үзэх хэрэгтэй.

АНУ энд стратегийн хувьд түрэн байрлаж Ази, Номхон далайд тогтворжуулах хүч болох үүргээ нэмэгдүүлж үүндээ Япон, БНСУ-ын оролцоо, ач холбогдлыг өргөтгөж, ОХУ,

БНХАУ хоёр арми, флотынхоо чанарыг сайжруулж стратегийн нөлөө, байрлалаа хамгаалан үлдэх, эдийн засгийн хүчээ зузаатгахад илүү анхаарч байгаагаас гадна энэ бүс нутагт их гүрнүүдийн хамтын ажиллагаа бэхжих чиглэл тодорхой болсон үед бид амьдарч байна. Хятадын проф. Хо Шүе Моухун “Бейжин Ревью” сэтгүүлд (1995.IX.25-X.I) хэвлүүлсэн өгүүлэлдээ өнөөдрийн ертөнцийг нэг хэт их гүрэн (АНУ), бусад 4 гүрэн (Европын холбоо, Япон, Орос, Хятад) хянах болов гээд “ Ази, Номхон далайн энх тайван, тогтвортой байдлын шийдвэрлэх хүчин зүйл нь АНУ, Япон, Хятад гэсэн гурвал боллоо гэж баталжээ. Үзэл суртлын тэмцэл, сөргөлдөөнөөс их гүрнүүд стратегийн шинэ тэнцвэрт байдал бий болгох холын зорилт хэрэгжүүлж эхэлсэн үе ч гэж болох юм.

Дунд болон бага буурай улсууд бүс нутгийн интеграцчилалд өөрийн байр суурьтай болох буюу бэхжүүлэх, хөгжлийн түшиц сууриа өргөтгөх бодлого барих болов. Бага, буурай улсуудын дотроос Монгол бол газарзүйн өвөрмөц байршилтай, түүхэн замнал, хөгжлийн загварын талаараа ч хослолгүй орон юм. Энэ нь Зүүн Хойд Ази (ЗХА)-д үүссэн геополитик, стратегийн шинэ нөхцөлд орохдоо өөрийн гэсэн өвөрмөц зам, бодлогыг эрэлхийлэхэд хүргэж улмаар ЗХА-ийн цэрэг, улс төрийн байдлыг харгалзах, хөгжлийн шинэ давуу зам сонгоход оршиж байсан юм.

Нөгөөтэйгүүр, ЗХА нь цэрэг, улс төрийн хүчний олон асуудалтай бөгөөд хүчний төвлөрлийн нэн сонирхолтой бүс юм. Стратегийн судалгааны олон улсын хүрээлэн (IISS)-гийн 1995/1996 оны цэргийн тэнцвэрийн тухай илтгэл зэргээс үзвэл, ЗХА-д цэргийн төвлөрөл их, цэргийн техник хэрэгсэл улам боловсронгуй болж давших чадвар нь ихсэж буй нь тодорхой байна. ЗХА-д байгаа ОУХ-ын Алс Дорнодын хэсгийн цэргийн тоо 560 000, БНХАУ-ынх 2 930 000, АНУ-ынх 106 200, Японы өөрийгөө хамгаалах хүчнийх 239 500 байгаа ажээ. Ертөнцийн энэ бүсэд газар нутгийн маргаан, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй байлгах, БНАСАУ, БНСУ-ыг өнөөгийн байдалд энх тайвнаар зэрэгцэн оршуулж яриа хэлэлцээний замд оруулах гэх мэтийн “Хүйтэн дайн”-ы үеэс ч уламжлалтай гэх асуудлын зэрэгцээ ардчиллыг бэхжүүлэх, эдийн засгийн нээлттэй бодлого, зах зээлд шилжих хандлагыг гүнзгийрүүлэх зэрэг шинэ асуудлууд ч гарч байна.

Монгол улсын хувьд гэвэл, ЗХА-д гарч буй эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжилд дөхөм үзүүлэх хандлагыг анхнаас нь дэмжиж Түмэн голын сав газрыг хөгжүүлэх олон улсын төсөлд оролцох, Монголын Зүүн хойд аймгуудыг энэ төсөлтэй холбон хөгжүүлэх эхлэл тавьсан хийгээд Монгол бол Европ ЗХА-ийг холбох гүүрийн үүргийг ирээдүйд гүйцэтгэх боломжтойг, тэр бүү хэл Сибирь-Японыг холбосон байгалийн хийг дамжуулах хоолой дамжин өнгөрөх магадлалтайг үндэс болгосон нь эдийн засгийн хөгжлийн бодлогод хийсэн нэг шинэчлэл гэж үзэж болох юм. Монголын дорнод хэсэг бол байгалийн баялаг ихтэй, мал аж ахуй, газар тариалан хөгжүүлэх бололцоотой тул тус улсын хөгжлийн ирээдүйд ихээхэн нөлөөтэйг ч бодох ёстой. Монгол Улсын нутгаар дамжуулан төмөр зам тавьж Европ, ЗХА-ийг холбох төслийн судалгаа хийж эхлэх шийдвэр гараад байгааг Монголын “Өнөөдөр” сонины 1997 оны долдугаар сарын 29-ний 147 дугаарт мэдээлсэн билээ.

АНУ-ын судлаач Роберт Маршаллын “Дорнын шуурга” номондоо тэмдэглэсэнчлэн Монгол бол Ази, Европыг танилцуулж худалдаа, харилцааг нь нээж өгсөн улс бөгөөд энэ үе бол их Чингисийн цаг юм.

Энэ бүхнийг онцлон тэмдэглэхийн хамт Монгол улс бол ЗХА-ийн орон мөн гэсэн томъёоллыг 1990-ээд онд нийтээр хүлээн зөвшөөрөх болсныг хэлэх хэрэгтэй. Энэ бол Монголын талаарх геостратеги, хөгжлийн үзэл баримтлалд гарсан чухал өөрчлөлт гэж үзэж байна. Гагцхүү энэ талаар цэгцтэй онол гарган нэг мөр болгож төрийн бодлогод баттай шингээх явдал эрдэмтэн, мэргэд, улс төрийн зүтгэлнүүдийн нэг зорилт болоод байна. Тэгэхдээ түүний үндэс нь дээр онцлон тэмдэглэсэн шинэчлэлт өөрчлөлтийн багц дүгнэлтүүд байх болов уу.

Төгсгөлийн оронд

-Монголын түүх, өнөөгийн болон цаашдын хөгжлийн нэг онцлог нь хил, соёл, түүх, шашин, уламжлалаа хамгаалж хүн төрөлхтнийг донсолгож байсан Монгол их гүрний түүхэн өлгий хэвээр үлдэж тусгаар тогтносон төр улсаа сэргээж чадсан явдал билээ. Монгол түүхэндээ хэдийгээр нүүж задарч нийлж салж тусгаар тогтнолоо алдаж явсан ч, Юань гүрэн, Чин улсын үеийг туулж хойт хөршийнхөө дагуул болж байсан ч

гэсэн улс гүрний хөгжлийн гол үндэс-тусгаар тогтнолоо сэргээн хамгаалж өнөө үед бэхжүүлж чадсан юм. Мөн ихээхэн европжсон мэт боловч нүүдлийн соёл иргэншлээ үндсэндээ авч үлдсэн орон билээ. Монгол улс нь газар нутгийн хувьд түгжигдсэн, их гүрнүүдийн геополитикийн өвөрмөц байдалд оршдог орон боловч 1990-ээд онд хөгжлийн болон геополитикийн цоо шинэ хүрээлэлд орсон, бололцоо нөхцөлийн хувьд шинэ үед шилжсэн орон гэж үзэх үндэстэй болов. Монгол орны улс төр, стратегийн байдал хөрш хоёр гүрэнтэйгээ нэн холбоотой ч АНУ, Япон зэрэг оронтой илүү нөхцөлдөж тэдний явуулж буй ардчиллыг дэмжих, Ази, Номхон далайн бүсэд стартегийн тогтворжуулах хүч болж байх бодлогын хүрээлэлд бас орлоо. Энэ нь тусгаар тогтнол аюулгүй байдлаа бэхжүүлэх, соёл иргэншлээ хөгжүүлэх шинэ нөхцөлийг Монголын хувьд бий болгов.

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хийсэн судалгаанд (UNDP Mongolia Background Paper examining possible LAC Characteristics, June 1993, Meeting of Donors, Tokyo, September 13-14, 1993) “ - “ Монгол нь нэн буурай хөгжилтэй орны тоонд орох нөхцөлд тун ойрхон орон” (р.37) гэж дүгнэсэн байдаг нь бусад колонийн дарлал, хараат байдалд байсан орнуудын хөгжлийн төвшинтэй ойролцоо байгааг илтгэж байгаа юм. Хөгжлийн энэ хоцрогдлоо давах нөхцөл, бололцоо өргөсч буй нь 1990-ээд оны өөрчлөлтийн нэг үр дүн мөн.

-Монгол улсын хөгжлийн бас нэг онцлог нь дэлхийн эдийн засгийн интеграцчиллын бүсэд, тэр дундаа Ази дахь эдийн засгийн бүлэглэлүүдэд өнөө хэр нь орж чадаагүй явдал. Энэ түгжигмэл байдлаас гарах түүхэн нөхцөл бүрэлдэж байна. АПЕК, ЗХА-д бүрэлдэж буй хамтын ажиллагааны бүтцэд аажмаар нэгдэн орох бололцоо нээгдэв.

-Хоёр хөрш гүрэнтэйгээ харилцаагаа шинэ зарчим, нөхцөлд өргөжүүлэн гүзгийрүүлэх, хөрөнгө оруулалтыг нь ихэсгэх, эдийн засгийн тусгай бүс хамтран байгуулах зэрэг харилцан ашигтай цогцолбор арга хэмжээ авах өргөн түүхэн бололцоо гарсныг үндэсний эрх ашгийнхаа үүднээс зөв ашиглах, эдийн засаг, худалдааны харилцаанд зоригтой, дорвитой ахиц гаргах үе нээгдэв.

Хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац, техник, технологийн бүтэц өөрчлөгдөж буй байдал, ОХУ-ын хүчирхэг хүнд үйлдвэрийн бүтэц, зах зээлийн өргөн боломж зэргийн дунд нь оршдог манай улс бусдаас давуу ашиглах нь гарцаагүй.

Ер нь хоёр хөршдөө хандах сэтгэл зүйн бэлтгэл, судалгаагаа эргэн харж шинэчлэх, байр суурь, үзэл баримтлалаа дээр доргүй цэгцлэх шаардлага ч гарч мэдэх юм.

“Орос, Хятад хоёр хэт их гүрний бөөрөнд байдаг өөрийнхөө замыг (гарах газрыг хайж байгаа Монгол улсад хоёр нэн их гүрний ээлжит тэмцлийн золиос болж хувирах аюул тулгарч байна” гэж 1991 онд Оросын нэг судлаач бичсэнийг д-р Д.Лхаашид иш татсан байдаг. Гэхдээ нэг хэсэг тодорхой үед энэ баримтлал хэрэгжихгүй гэдгийг 1990-ээд оны Хөгжлийн хандлага харуулж байна гэсэн үзэл санаа байгааг миний бие ч хуваалцдаг юм.

-1990-ээд онд Монгол улс болон НҮБ, түүний системийн санхүү эдийн засгийн байгууллагууд, олон улсын бусад байгууллагын харилцаанд чанарын ихээхэн өөрчлөлт гарав. Зээл, тусламж ихээхэн авах болж олон улсын хамтын нийгэмлэгийн тусламжийн системд нэгдсэн нь чухал ач холбогдолтой хүчин зүйл мөн. Энэчлэн дэлхийн бусад улс гүрэнтэй өргөн харилцах болж Монголыг дэмжигч, хандивлагчдын бүлэг бий болсон байна.

Боловсрол, шинжлэх ухаан техникийн мэдлэг, чадварын хувьд ч хараат байдлаас гарч дэлхийн олон оронд сурсан, янз бүрийн хэл мэддэг хүний тоо олширч орос хэлний “тойрог”-оос аажмаар мултрах зам нээгдэв.

Эдгээрээс үндэслэн хийх дүгнэлт гэвэл:

“Хүйтэн дайн” дуусч дэлхийн улс төр, стратегийн байдалд гарсан өөрчлөлт нь газарзүйн байрлалаасаа болж хэдэн давхар “түгжигдмэл” байдалд оршиж ирсэн, коммунизмын болон их гүрний “барьцаанд” байсан Монголын хувьд дэлхийн соёл иргэншил, хөгжлийн замд орох “хувьсгалын тохироо”-г бүрдүүлэв. Өөрөөр хэлбэл, нэг хэт их гүрэн задарч дагуул улстай байх улс төр, үзэл суртлын бодлого нь дампуурч нөгөө хэт их гүрний нь стратегийн тэнцвэржүүлэх, тогтворжуулах үүрэг нь нэмэгдэж бусад их гүрний зохицон өөрийн стратегийн эрх ашгаа хамгаалах байдал бий болсон нь Монголын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хөгжлийн шинэ замд орох түүхэн бололцоог бий болгов.

1990-ээд онд Монголын хувьд бүрэлдсэн геополитикийн нөхцөл нь урьд өмнө байгаагүй үнэхээр шинэ, нааштай зүйл

бөгөөд энэ байдал түүхэн тодорхой хугацаанд магадлал ихтэй.

Ашигласан болон анхаарсан ном, хэвлэл

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1994 он)
2. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (1994 он)
3. Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Ардын эрх сонин, 1996.XI.22
4. Р.Болд. Монголын аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлогын зарим асуудалд, УБ, 1996 он
5. Д.Лхаашид Монголын нийгэм төрийн аюулгүй байдал, Монгол хүнийг хөгжүүлэх философи, УБ, 1996 он
6. Х.Олзвой: Гадаад бодлогын шинэчлэлийн тухай хувийн бодол “Дорно-Өрнө” сэтгүүл, 1996 он, №1; School of Foreign Service Publication: New World Order in Post-Cold War Era in Asia, Ulaanbaatar, 1996, p.31-41
7. Kh.Olzvoy “Mongolia: Aiming the Land-Bridge” See: Proceedings of the International Conference “Tumen River Area Development Project ...”, The Sejong Institute, Korea, Seoul, 1995, p.196-177
8. Kh.Olzvoy “A Mongolia's View on Economic Development and Cooperation” The Mongolian Journal of International Affairs, №3, 1996, p.60-67
9. Kh.Olzvoy “Economic Cooperation in NEA” “Look the Northeast” policy for Mongolia A paper presented at the Internatiol Conference on “Asia beyond the year 2000”, Ulaanbaatar, 20-21 March 1997
10. Robert Marshall “Storm from the East” The University of California Press, Berkeley and Los Angeles, California, 1993
11. UNDP, Mongolia: Background Paper Examining possible LDC Characteristics, Meeting of Donors, Tokyo, September 13-14, 1993
12. IISS, Military Balance 1995/1996
13. Бейжин ревью, 1995.9.25-10.

14. И.А.Николайчук “Старый-Хартлэнд и новый мир: альтернатива-морю или межцивилизационный мир” School of Foreign Service National University of Mongolia Mongolia's Geopolitics: past Present and Future, Proceedings of the International Conference, March, 1995, Ulaanbaatar

15. Ю.Кручкин. Выдержка из доклада “Генезис российских интересов в Монголии”, там же.

16. Gerald Robbins “The Post-Soviet Heartland: Reconsidering Mackinder”, Euroasian Studies, TICA, 3, Fall 1994

**ОХУ-ын дотоод, гадаад бодлогын
талаарх зарим ажиглалт**

Улс төр судлаач Д.Баярхүү

Энд бичсэн зүйл судлаачийн хувийн дүгнэлт тул Монгол Улсын албан ёсны бодлоготой нийлэх албагүй, уншигч болгоны сэтгэлд тэр бүр нийцэхгүй байж болохыг анхаарна уу.

Нэг. Оршлын оронд

Орос орон, орос хүн монголчуудын сэтгэлд дотно санагддаг. Өмнөд хөршөө газар дор ортол хараан зүхэж, хардаж сэрдэж байсан жилүүд тэгтлээ холдоогүй байна. Тэр үетэй харьцуулахад /бид бол тэр үеийн үзэл суртлын бүтээгдэхүүн билээ-Зох/ Оросын ард түмний талаар хэзээ ч тийм зэмлэл, гүтгэлэг, дайсагнал манай зүгээс гарахгүй мэт. Дэлхийд их бага хоёр улс, хоёр үндэстэн найрамдан нөхөрлөхийн үлгэрийг ганцхан Монгол, Зөвлөлт хоёр л үзүүлсэн гэж нотлох хүн зөндөө. Манай ахмад насныхан бүгд л тэгж ойлгож яваа. Үүнд буруу байхгүй. Тэгж ойлгуулж түүнийгээ хүн ардын толгойд дэс дараалан хийсэн нам, засгийн суртал нэвтрүүлэг үнэхээр хүчтэй байсных.

XXI зууны босгон дээр үүнийг сэргүүлсэн үзлээ би энд сийрүүлэх гэж байна. Эцсийн бүлэгт Орос ба Оросын ард түмэн манай гадаад дахь нэг баталгаа болж чадах уу, хил залгаа оршихын учир, түүнээс бидэнд тусах тусгал, ач холбогдол ирээдүйд хэрхэн эргэх вэ? гэдгийг урьдчилан таах гэж оролдоё. Оросын өнөөгийн дотоод амьдрал, эдийн засгийнх нь урвуу дэвшил /уналтыг хэлж буй- Зох/, гадаад бодлогын мухардал